



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2015 оны 8 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 166

Улаанбаатар
хот

Үүрэг хариуцуулах тухай

1. Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2015 оны 77 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Засгийн газрын орон гарсан зарим гишүүнийг нөхөн томилох хүртэл хугацаанд түүний үүргийг дор дурдсаны дагуу хуваарилан хариуцуулсугай:

1) Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдын үүргийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүйн сайдад;

2) Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын үүргийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад хэргийн сайдад;

3) Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдын үүргийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад;

4) Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайдын үүргийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Уул уурхайн сайдад;

5) Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдын үүргийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэрийн сайдад;

6) Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөрийн сайдын үүргийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдад.

2. Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан үүргийг Засгийн газрын орон гарсан гишүүдийг нөхөн томилох хүртэл хугацаанд хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу хариуцан гүйцэтгэж байхыг холбогдох сайд нарт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ